



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГНИЙ ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 1/20

Мандалтөв

Г

Зөвлөл байгуулах тухай

Т


Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 195 дугаар тогтоолоор батлагдсан "Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах журам"-ын 5 дугаар зүйлийн 5.2-ийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах талаар шийдвэр гаргах, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэгтэй Зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

- |                       |   |
|-----------------------|---|
| Зөвлөлийн дарга:      | -Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга   |
| Нарийн бичгийн дарга: | -Орон нутгийн өмчийн газрын дарга   |
| Гишүүдэд:             | <ul style="list-style-type: none"> <li>-Хууль, эрх зүйн хэлтсийн дарга</li> <li>-Аймгийн Цагдаагийн газрын дэд дарга</li> <li>-Аймгийн Автомэдрэвийн төвийн дарга</li> <li>-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн Байгал орчин, аялал жуулчлал, ашигт малтмалын бодлого хариуцсан мэргэжилтэн</li> <li>-Санхүү төрийн сангийн хэлтсийн Төрийн сангийн төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн</li> </ul> |

Хоёр. "Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах журам"-ын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Зөвлөлийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан "Орон тооны бус Зөвлөл байгуулах тухай" аймгийн Засаг даргын 2016 оны А/108 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.



ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ

Ж. МӨНХЧУЛУУН

0200842

